

Улаанбаатар хотын Төмөр Замын төв эмнэлэг

1938 онд ЗХУ-эн /Хуучнаар/-ийн тусламжаар Улаанбаатар хот -Налайхын хооронд нарийн төмөр зам тавигдаж, замчид тэдний гэр бүлийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эмнэлгийн салбаруудыг байгуулан ажиллуулсан түүхтэй.

1951 он 01 дүгээр сарын 5-анд одоогийн Пунцоглин хийдийн байранд 12 оронтой тоотой анх нээгдэж,80-аад хувь нь Зөвлөлтийн мэргэжилтнүүд ажиллаж, амбулаторийн тусламж үзүүлж байв.

1956.11 дүгээр сарын 1-энд одоогийн ХЗӨХэсгийн байранд шилжин орж, хүүхэд, мэс засал, эмэгтэйчүүд, чих хамар, хоолой, нүд шүдний нарийн мэргэжлийн тусламжийг үзүүлэх болсон.

1958.он 75 ор бүхий хэвтүүлэн эмчлэх тасаг нээгдсэн.

1964 он. Одоогийн хүүхдийн тасгийн барилга ашиглалтад орж, 200 ортой ажиллах болсон.

1965 он. Зүү шив үүр шавар физикийн эмчилгээний кабинет нээгдсэн.

1969 он.Зүрх судасны кабинет, биохимийн лаборатори байгуулагдсан.

1970 он. Үйлдвэр цех,хүүхдийн хэсгүүдийг шинээр байгуулжээ.

1984 он. Хүүхэд том хүний сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг бие дааж байгуулагдсан.

1985 он. Тэжээлийн доройтол,сульдаатай хүүхэд сувилах "Энхжин" сувилал байгуулагдсан.

1986 он. Бөөрөлжүүтний рашаан шаврыг түшиглэн тулгуур эрхтний эмгэг, арьсны харшилтай хүмүүсийг сувилах "Булагтайн" сувилал нээгджээ.

1990 он. Амбулаторийн шинэ байрыг ашиглалтад оруулж оношлог ооны чиглэлээр рентген, эхография,эндоскопын кабинетуудыг шинээр байгуулж, нөхөн сэргээх эмчилгээ, биеийн тамир зүү, бариа засал, эмчилгээг улам өргөжүүлж персонал компьютер, шинжилгээний анализатортай болж, сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг нээж, уушиг улаан хоолой, ходоод гэдэсний мэс заслыг амжилттай хийдэг болсон.

1991 он. 330 ортой эмнэлэг, өдөрт 400-600 хүнийг үзэх хүчний чадал бүхий поликлиник,100 их эмч, 200 гаруй дунд мэргэжилтэнтэй ажиллаж ,17000 төмөр замчид, тэдний гэр бүлийн 6000 хөдөлмөрчдийн эрүүл мэндийг хамгаалан ажиллаж, түүхэн 50 жилийн ойг угтсан.

2000 он. 25 ортой мэдрэлийн тасгийн шинээр нээсэн.

2001 он. Эрчимт эмчилгээний болон хүлээн авах тасгийг тусад нь зохион байгуулан ажиллуулав.

2002 он. Зүрхний эхогийн кабинет шинээр нээж, Герман улсад үйлдвэрлэгдсэн зүрхний өнгөт эхү аппарат болсон.

2003 он. Төмөр замын эрүүл мэндийн байгууллагуудын 2007 он хүртэлх стратегийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлээ тодорхойлж, "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах", "Хүний нөөцийн хөгжлийн цогц менежмент" зэрэг хөтөлбөрүүдийг боловсруулан ажиллаж, эмчилгээ, оношлог оог сайжруулах зорилгоор Япон улсад үйлдвэрлэсэн. Olympus фирмийн GIF-XQ-40 маркийн гастроскопийн аппарат, тархины судасны эмгэгийг оношлох доплерографын аппарат, сэхээний тасагт Амбу, хүүхдийн халаадаг жин, эмгэг ан-атомын кабинетад электрон микроскоп зэрэг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангасан.

2004 он. Эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг мэргэжлийн дээшлэхтэй онцгой анхааран "2007 он хүртэлх сургалтын нэгдсэн хөтөлбөр" боловсруулан жил бүрийн дэд хөтөлбөртэй ажиллаж эхэлсэн.

2005 он Япон улсын Хитачи фирмд 2005 оны 9 сард үйлдвэрлэгдсэн телевизийн систем бүхий алсын удирдлагатай, зургийн тодрол, харалт сайтай 1 удаадаа 50-60 хүнд үйлчлэх бололцоотой "Populus TU513 маркийн рентген суурин аппарат шинээр суурилуулсан, лабораторийн тасагт Герман улсын Нитат пүүсийн "Humalazar 3000 автомат анализатортай болсон.

Тус эмнэлэг нь 1800 км урт төмөр зам дагуу ажиллаж амьдарч буй төмөр замчид, тэдний ар гэрийн нийт 51706 хүний эрүүл мэндийг хамгаалж, хэвтүүлэн эмчлэх 215 ор бүхий стационар, 600 хүнд үйлчлэх хүчин чадал бүхий 15 нарийн мэргэжлийн кабинет, пара клиникийн 5 тасагтай амбулатори, 1 ээлжид 120 -150 кг цагаан хэрэглэл угаах хүчин чадал бүхий угаалга, 60м² багтаамжтай хүчилтөрөгчийн байр зэрэг 15 хэсэг эмнэлгийн зориулалтын байран үйл ажиллагаа явуулж, 335 орон тоотой үндсэн нарийн мэргэжлийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг оношлог оо, эмчилгээ сувилгаа, асаргаа, нөхөн сэргээх, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тус тус үзүүлж байна.

Эмнэлгийн дээд 82, дунд 41 мэргэжилтэнтэй, Эмч нарын 42,6% нь нарийн мэргэжлийн хос мэргэжилтэй одоо клиник эмнэлэгт профессор 1, хүүхдийн харшлын чиглэлээр аспирантурт зүрхний ЭХО, зурхай эрүүл мэндийн нягтлан бодогч бүртгэл, сэтгэл судлалын сэдвээр тус тус докторант 4 хүн суралцаж тэргүүн зэрэгтэй эмч 12 мэргэшсэн нягтлан бодогч 1, магистр цолтой эмч 19, бакалавр цолтой эмч 3 буюу 3,9% бакалавр боловсролтой сувилагч, бага эмч 25 буюу 17,4% тус тус ажиллаж байна.

Шугам дагуух 4 нэгдсэн эмнэлэг 6 их эмчийн салбар, 9 бага эмчийн салбарыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Эмнэлгийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд боловсруулалт хийн НЭМГ, ХСҮТ, Шүүх эмнэлэг эмгэг судлалын төвд хугацаанд хүргүүлсэн. Замын хэмжээний эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайланд статистик боловсруулалт хийн судалгаа тайланг зохион явуулахаар бэлтгэж ажилдаа орсон. Хүүхдийн Клиникийн сувилал №41